1044

*Засгийн газрын Хэрэг эрхлэх газрын*
*даргын 2023 оны 98 дугаар тушаалын*
*6 дугаар хавсралт*

# ГААЛИЙН ЕРӨНХИЙ ГАЗРЫН ДЭРГЭДЭХ БҮРДҮҮЛЭЛТИЙН ЦАХИМ ТӨВИЙН ЗӨРЧИЛТЭЙ ТЭМЦЭХ, ЧИГЛЭЛ ХАРИУЦСАН ГААЛИЙН УЛСЫН АХЛАХ БАЙЦААГЧ ОДОНЖИЛИЙН ШАГДАРЫН 2024 ОНЫ ЭХНИЙ ХАГАС ЖИЛИЙН ГҮЙЦЭТГЭЛИЙН ТАЙЛАН

**Нэг. Гүйцэтгэлийн зорилт, арга хэмжээний биелэлт**

| Д/д | Зорилтыг хэрэгжүүлэх арга хэмжээ | Шалгуур үзүүлэлт | Гүйцэтгэлийн түвшин | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| | | | Суурь түвшин | Хүрэх түвшин | Хүрсэн түвшин (биелэлт) | Эхэлсэн, дууссан хугацаа | Биелэлтийн хувь |
| | 1 | 2 | 3 | 4 | 5 | 6 | 7 |
| **Зорилт 1: Олон улсын хууль ёсны худалдааг хөнгөвчлөх, түүний аюулгүй байдлыг хамгаалах** | | | | | | | |
| 1. | Хууль ёсны гадаад худалдааг хөнгөвчлөх чиглэлээр зохион байгуулсан арга хэмжээ | Хэрэгжилт, хувиар, гүйцэтгэлээр | - | Гаалийн бүрдүүлэлтийн автоматжуулсан системийн сайжруулалт, өөрчлөлт, хөгжүүлэлтийн саналыг тухай бүрт нь гарган, МТТ-д хүргүүлсэн байна. | Гадаад худалдааг хөнгөвчлөх чиглэлээр дараах ажлуудыг хийж хэрэгжүүлээд байна. Үүнд:<br>1. Гаалийн бүрдүүлэлтийн үйл ажиллагааг хялбарчилах, бүрдүүлэлтийн үе шатад CAIS программ-д гарч буй хүндрэлийг шийдвэрлэхээр саналыг боловсруулан Мэдээллийн технологийн газарт 2024 оны 05-р сарын 09-ний өдөр 62 тоот дотоод зурвасыг хүргүүлсэн. Дотоод зурвасын дагуу Мэдээллийн технологийн газрын ГУАБ Н.Мөнхзул, ГУБ П.Хорлоо, У.Энхсайхан нартай Бүрдүүлэлтийн цахим төвөөс ГУАБ нар уулзалт хийн хүндрэл, бэрхшээлийн талаар зохих мэдээллийг хүргэсэн.<br>2. Гаалийн харилцаанд оролцогч нар нь цахимаар өөрөө бараагаа мэдүүлэхэдээ барааны байршил, барааны код, оноосон нэр, онцлог шинж, горимын код болон ААН-ээр мэдүүлэхдээ иргэнээрээ тоон гарын үсгээрээ мэдүүлэх зэрэг алдаа их гаргаж байгаа тул эдгээрийг засах боломжийг олгох хариуцлага алдсан тохиолдолд бага түүнд тохирсон бага торгуультай /Гаалийн мэдээллийн систем ашиглах журам/-ыг боловсруулах шаардлагатай байгаа талаар МТТ-ийнхэнд хэлсэн. | 2024.01.01-2024.06.05 | 95 |
| 2. | Гаалийн бүртгэгдсэн мэргэжилтний үйл ажиллагаа | Хэрэгжилт, гүйцэтгэлээр | - | Гаалийн зуучлагчийн үйл ажиллагаа эрхлэхэд тавигдах стандартыг | 1. Гаалийн бүртгэгдсэн мэргэжилтний давтан сургалтад 2024 оны 04-р сарын 03-ны өдөр “Гаалийн бүртгэгдсэн мэргэжилтний анхаарах зүйлс, зөрчлөөс урьдчилан сэргийлэх” сэдвээр хичээл заасан.<br>2. Шинэчлэн боловсруулж буй "Гаалийн зуучлагчийн үйл | 2024.01.01-2024.06.05 | 95 |

| | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| | | | | боловсруулж, хэрэгжилтэд хяналт тавьж ажилласан байна. | ажиллагаанд хяналт тавих журам"-ын төсөлд 04 сард санал өгсөн.<br>3. Гаалийн ерөнхий газарт 2024 оны 05-р сарын 08-ны өдөр Гаалийн зуучлагчийн үйл ажиллагааг боловсронгуй болгох, олон улсын жишигт нийцүүлэх, мөн гаалийн зуучлагч, гаалийн бүртгэгдсэн мэргэжилтэнд тавих хяналтын тогтолцоо, хариуцлагыг өндөржүүлэх зорилгоор "Гаалийн зуучлагчийн үйл ажиллагаанд хяналт тавих журам"-ыг шинэчлэн боловсруулж, тус журмын төслийг гадаад худалдаанд оролцогчид, гаалийн зуучлагч нарт танилцуулах нээлттэй хэлэлцүүлэгт оролцсон. | | |
| 3. | Үндсэн шалгуурт тусгагдаагүй бусад чиг үүргийн хэрэгжилт | Хэрэгжилт, гүйцэтгэлээр | - | Бүрдүүлэлтийн цахим төвийн эрх бүхий албан хаагч нарын бичиг баримтын шалгалт хийх явцад илрүүлсэн зөрчилд ЗШША-ны талаар зөвлөгөө өгөх | Бүрдүүлэлийн цахим төвийн эрх бүхий албан тушаалтнуудын ажил үүргээ гүйцэтгэн бичиг баримтын шалгалт хийх явцдаа илрүүлсэн зөрчлийн талаарх мэдээллийг ЗШШТ хуулийн 1.8-д заасны дагуу зөрчил үйлдэгдсэн нутаг дэвсгэрийн харьяаллын дагуу шилжүүлэн 28 зөрчлийг шийдвэрлүүлсэн. Бүрдүүлэлтийн цахим төвийн ГУБ нарын илрүүлсэн 8 зөрчилд Зөрчлийн тухай хуулийн 4 зүйлчлэлээр 16.86 сая төгрөгийн торгуулийг ногдуулан 12.72 сая төгрөгийн татварыг нөхөн төлүүлсэн. | 2024.01.01-2024.06.05 | 92 |
| 4. | Гаалийн байгууллагын 2024 оны Авлигын эсрэг үйл ажиллагааны төлөвлөгөөний хэрэгжилтийг хангах | Хэрэгжилт, гүйцэтгэлээр | - | Нэгжийн чиг үүргийн хүрээнд төлөвлөгөөний хэрэгжилтийг хангаж ажилласан байна. | 1. Гаалийн байгууллагын 2024 оны авлигын эсрэг үйл ажиллагааны төлөвлөгөөний биелэлтийг хангаж ажиллаж байна.<br>2. 2023 оны ГУБ-ын ХОМэдүүлэг болон Бүрдүүлэлтийн цахим төвд 2024 оны 03-р сарын 15-ны өдрөөс шилжин ажиллаж шинээр томилогдсон албан тушаалын ХОМэдүүлгийг 30 хоногийн дотор тайлагнасан.<br>3. Бүрдүүлэлийн цахим төвд Засгийн газрын 1111, Гаалийн ерөнхий газрын 1800-1281 тусгай дугаарын утсанд ирсэн гомдол, мэдээллийн дагуу хийсэн ажиллагааны талаарх шийдвэрлэлтийн байдлыг 7 хоног бүрд Шуурхай хяналтын төвийн албан хаагч нарт хүргүүлэн cerp.ecustoms.mn программд хаалт хийлгэж байна. | 2024.01.01-2024.06.05 | 90 |
| **Зорилт 2: Улсын хилээр хууль бусаар бараа, тээврийн хэрэгслийг нэвтрүүлэхтэй тэмцэх** | | | | | | | |
| 1. | Гаалийн хилээр нэвтрүүлэх барааны бичиг баримтын шалгалт хийсэн байдал | Хэрэгжилт, гүйцэтгэлээр | - | 1. Бичиг баримтын бүрдүүлэлтийн хэвийн үйл ажиллагааг хангаж, бичиг баримтын шалгалтыг | Гаалийн хилээр нэвтрүүлэх барааны бичиг баримтын шалгалтыг горимын шаардлага, холбогдох хууль тогтоомж, журам заавурын хүрээнд бүрэн алдаагүй хийхэд ГУБ нарт дэмжлэг үзүүлэн, заавар чиглэлийг хуулийн хүрээнд өгч, хамтран ажиллахын зэрэгцээ дараах ажлуудыг хийж хэрэгжүүлээд байна. Үүнд:<br>1. Төвийн даргын баталсан "ГУАБ нарын хариуцсан бүлэг болон газар, хорооны хуваарь"-ийн дагуу БТКУС-ын 01-24, 93-97-р | 2024.01.01-2024.06.05 | 90 |

| | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| | | | | горимын шаардлага, хууль тогтоомжийн хүрээнд бүрэн алдаагүй хийж, зохих төлөвт бүрэн байршуулсан байна.<br>2. Судалгаа, дүн шинжилгээг хийж, санал дүгнэлтийг удирдлага болон холбогдох нэгжүүдэд хүргүүлж, мэдээллээр хангаж ажилласан байна.<br>3. Гаалийн газар, хороодын удирдлагуудтай харилцан мэдээлэл, солилцож, хамтран ажилласан байна. | бүлгүүдэд хяналт тавьж, бичиг баримтын бүрдүүлэлт хариуцсан гаалийн улсын байцаагч нарт заавар, зөвлөгөө өгч хамтран ажиллаж байна.<br>2. Мөн 7 хоног бүрийн мягмар гарагт гарч буй алдаа болон шинээр хэрэгжиж байгаа хууль тогтоол, тушаал, шийдвэрийн талаар танилцуулж, зарим бараагаар мэргэжлийг хүнийг урьж авчран сургалт зохион байгуулж, мэдээ мэдээллийг түгээж, мэдлэг чадварыг нэмэгдүүлэн ажиллаж байна.<br>3. Гаалийн бүрдүүлэлтийг явцад БНХАУлсаас импортлож буй зарим барааны мэдээллийг ЗҮГГ-ын удирдлага, холбоо баригч Ариунзаяаас авч бичиг баримтын шалгалтыг хийсэн. /тоног төхөөрөмж, өндөр үнэ бүхий машин механизм/<br>4. Хариуцсан 01-24 дүгээр бүлгийн барааны 2023, 2024 оны 05-р сарын судалгааг хийж барааны өөрчлөлтүүдийг харьцуулан судлаж байна.<br>5. Бүрдүүлэлтийн цахим төвийн гаалийн улсын байцаагч нар бичиг баримтын шалгалт хийх явцад зөрчлийн шинжтэй үйлдэл илэрсэн тохиолдолд Зөрчил шалган шийдвэрлэх тухай хуулийн 1.8 дугаар зүйлд заасны дагуу зөрчил үйлдэгдсэн нутаг дэвсгэрийн эрх бүхий албан тушаалтан нартай холбогдож зөрчлийн талаарх мэдээллийг тайлбарлан, тэмдэглэлийг хүргүүлэн хяналт тавьж ажилласан. | | |
| 2. | Гаалийн бүрдүүлэлтэд гарсан алдаа болон зөрчил илрүүлэлт, шийдвэрлэлт, алдааг бууруулах чиглэлээр зохион байгуулсан ажил | Илрүүлсэн зөрчлийн тоо, нөхөн төлүүлсэн татварын дүн, торгуулийн дүн | - | Бичиг баримтын шалгалтын явцад илрүүлсэн зөрчлийн тоо, нөхөн төлүүлсэн татвар, торгуулийн дүнг өмнөх оны мөн үеэс 2 хүртэл хувиар нэмэгдүүлнэ. | Бүрдүүлэлийн цахим төвийн эрх бүхий албан тушаалтнуудын ажил үүргээ гүйцэтгэн бичиг баримтын шалгалт хийх явцдаа илрүүлсэн зөрчлийн талаарх мэдээллийг ЗШШТ хуулийн 1.8-д заасны дагуу зөрчил үйлдэгдсэн нутаг дэвсгэрийн харьяаллын дагуу шилжүүлэн 28 зөрчлийг шийдвэрлүүлсэн. Бүрдүүлэлтийн цахим төвийн ГУБ нарын илрүүлсэн 8 зөрчилд Зөрчлийн тухай хуулийн 4 зүйлчлэлээр 16.86 сая төгрөгийн торгуулийг ногдуулан 12.72 сая төгрөгийн татварыг нөхөн төлүүлсэн.<br>Бүрдүүлэлтийн цахим төвийн эрх бүхий албан тушаалтнуудын илрүүлсэн зөрчлийг 2023 оны мөн үетэй харьцуулвал зөрчлийн тоо, нөхөн төлсөн татварын дүн, торгуулийн дүн нэмэгдсэн үзүүлэлттэй байна. | 2024.01.01-2024.06.05 | 90 |
| 3. | Гаалийн бүрдүүлэлтийн горимын хэрэгжилт, | Хэрэгжилт, гүйцэтгэлээр | - | Гаалийн бүрдүүлэлтийн горимын хэрэгжилтийг | Засгийн газрын 2024 оны 180 дугаар тогтоол гарсантай холбоотойгоор 2024 оны 05-р сарын 01-ний өдрөөс эхлэн Гаалийн албан татвараас чөлөөлөх мал, амьтны тэжээл, тэжээлийн нэмэлт болон улаанбуудайн гурлын жагсаалтад | 2024.01.01-2024.06.05 | 90 |

| | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| | гаалийн тариф, гарал үүслийн хяналт | | | хангуулж ажилласан байна. | хамрагдаж буй Оросын холбооны улсаас импортлогдож буй зарим барааны талаар 2024 оны 05-р сарын 29-ний өдөр 71 дугаартай дотоод зурвасыг хүргүүлсэн. | | |
| 4. | Барааны ангилал, гаалийн үнэ, үнэлгээг үнэн зөв мэдүүлэх, тодорхойлох чиглэлээр зохион байгуулсан ажил | Хэрэгжилт, гүйцэтгэлээр | - | • Бичиг баримтын бүрдүүлэлтийн үе шатанд барааны ангиллын хяналтыг хэрэгжүүлж, ангиллын луйврыг илрүүлж ажилласан байна.<br>• Барааны лавлах санг баяжуулж ажилласан байна. | • Гаалийн байгууллагад бараагаа мэдүүлэхдээ барааны ангилал, онцлог шинж, зориулалтыг худал мэдүүлэн барааны ангиллын луйвар хийж болзошгүй, тариф өндөртэй барааны талаарх мэдээллийг Бүрдүүлэлтийн цахим төвийн нийт гаалийн улсын байцаагч нарт мэдээлэл хүргүүлэн ажиллаж байна. Мөн барааны ангилал, гаалийн төв лабораторийн дүгнэлтэд зөрүүтэй, ангилал зөрчсөн тохиолдолд Зөрчлийн тухай хуулийн 11.21 дүгээр зүйлийн 12 дахь хэсэгт заасны дагуу арга хэмжээг авч шийдвэрлэдэг талаар ГУБ нарт хэлж бичиг баримтын шалгалт хийсэн тэмдэглэл үйлдэн ЗШШТ хуулийн 1.8-д заасны дагуу зөрчил үйлдэгдсэн нутаг дэвсгэрийн харьяаллын дагуу шилжүүлэн шийдвэрлэж байна.<br>• Гаалийн мэдээллийн автоматжуулсан систем програмын “Бүрдүүлэлт” цэсний “Татварын хувь хэмжээ” дэд цэсний “Лавлах сан” хэсэгт Монгол улсын хилээр нэвтрэн импортын бүрдүүлэлт хийж буй тээврийн хэрэгслийн үйлдвэрлэл, марк, загвар, хөдөлгүүрийн багтаамж зэрэг нийт мэдээллийг оруулсан байна.ыг илрүүлж | 2024.01.01-2024.06.05 | 95 |
| **Зорилт 4: “Гаалийн байгууллагын дэд бүтэц, чадавхыг бэхжүүлэх”** | | | | | | | |
| 1. | Өргөдөл, гомдол, маргааныг шийдвэрлэсэн байдал | Хэрэгжилт, гүйцэтгэлээр | - | 1. Бичиг баримтын бүрдүүлэлтийн үе шатанд ирсэн өргөдөл, гомдолыг холбогдох хуульд заасан хугацаанд нь бүрэн шийдвэрлэсэн байна.<br>2. Шийдвэрийн мэдээллийг кайс систмеийн маргаан шийдвэрийн сан, дуудлагын төвийн шийдвэрлэх жагсаалтад бүрэн оруулсан байна. | Бүрдүүлэлтийн цахим төвийн гомдол, мэдээлэл хүлээн авах 7000-1280 утасны дуудлага хүлээн авах үйл ажиллагааг нэмэгдүүлэх зорилгоор Мэдээллийн технологийн газрын ГУБ Сүхбатыг тус төвд урин 7000-1280 утасны дуудлагыг хүлээн авах урсгалыг 2 шугамаар 3 оролтоор авах ба дуудлага хийхэд “Бүрдүүлэлтийн цахим төвийн үйл ажиллагаатай холбоотой асуудлаар 7000-1280 утас, бусад асуудлаар Гаалийн лавлах 1800-1281 утсанд хандах” талаар текст хэлдэг байх, мөн 7000-1280 утас завгүй ярьж байх тохиолдолд “Таны өмнөх хэрэглэгчтэй ярьж байгаа тул түр хүлээнэ үү” гэх зэрэг текст хэлдэг байхаар саналыг өгч хийлгүүлсэн ба Шуурхай хяналтын төвөөс Гаалийн ерөнхий газраас Гаалийн байгууллагад ирж буй санал, гомдол, мэдээллийн нэгдсэн хяналтыг бий болгох зорилгоор гаалийн газар, хороо болон төвд ажиллаж буй тусгай дугаарын утсуудыг ГЕГ-т нэгтгэн нэгдсэн дуудлагыг авч харьяалах нэгжид нь ГЕГ-аас шилжүүлж Шуурхай хяналтын төвөөс зохион байгуулж байхаар болсон.<br>Шуурхай хяналтын төвөөс гаалийн газар, хороодын тусгай дугаарын утсанд нэгдсэн журмаар тохиргоо хийж байгаатай холбогдуулан 4 утсыг хүргүүлсэн. Тус утаснаас 7777-1281 | 2024.01.01-2024.06.05 | 90 |

| | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| | | | | | дугаарын 1 утсыг шинэ тохиргоонд оруулан тус төвд 27-ны өдрөөс ажлуулж эхэлсэн.<br>Бүрдүүлэлтийн цахим төвийн 7000-1280 дугаарын утсанд 2024 оны 01-р сарын 01-ний өдрөөс 05-р сарын 31-ний өдрийг дуусталх хугацаанд нийт 5000 гаруй дуудлага бүртгэгдсэн ба тус дуудлагын дагуу гаалийн бүрдүүлэлтийг нягтлан үзэж холбогдох арга хэмжээнүүдийг тухай бүр авч ажилласан байна.<br>Бүрдүүлэлтийн цахим төвийн ГУАБ нар 7 хоногоор ээлжлэн БТКУС хариуцан гомдол мэдээллийг шийдвэрлэн ажиллаж байсан ба 4 сараас эхлэн зохион байгуулалтын өөрчлөлт оруулан 1 сарын хугацаагаар хуваарь гарган хуваарийн дагуу ажилдаг болсон. 2024 оны 4 сард БТКУС хариуцан өргөдөл, гомдол, үнэлгээний маргааныг холбогдох хууль тогтоомж, журам зааврын хүрээнд бүрэн шуурхай шийдвэрлэн ажилласан.<br>2024 оны 1-р сараас 5 сар хүртлэх хугацаанд өргөдөл, гомдолыг хариуцан ажиллахдаа tsakhimgaali@customs.gov.mn цахим хаягаар ирүүлсэн 88 гомдол, 135 хүсэлтийн шийдвэрлэлтэд хяналт тавьж, холбогдох албан тушаалтануудтай зөвлөлдөн, хугацаанд нь хариуг нь өгч, бүрэн шийдвэрлэн ажилласан байна. | | |
| 2. | Бодлогын баримт бичгийн зорилт, арга хэмжээний хэрэгжилт | Илрүүлсэн зөрчлийн тоо, нөхөн төлүүлсэн татварын дүн, торгуулийн дүн | - | 1. Бодлогын баримт бичигт тусгагдсан арга хэмжээний хэрэгжилтийг тайлагнана. | Төвийн 2024 оны гүйцэтгэлийн төлөвлөгөө боловсруулан, ажил хариуцсан ГУАБ нараас санал авч төлөвлөгөөний зарим ажилд засвар өөрчлөлт оруулан төвийн даргаар хянуулан, батлуулахаар ГЕГ-ын ЗУГ-т хүргүүлсэн.<br>Эхний хагас жилд зөрчлийн талаарх 2 гомдол, мэдээлэлд Зөрчил шалган шийдвэрлэх ажиллагаа явуулан шийдвэрлэсэн.<br>**Зөрчлийн 2402000024 дугаартай хэрэг:**<br>Нийслэлийн прокурорын газраас 2024 оны 01-р сарын 11-ний өдрийн 1/368 тоот албан бичгээр зөрчлийн 2402000025 дугаартай хэргийг тусгаарлан зөрчлийн хэрэг бүртгэлтийн ажиллагаа хийлгүүлэхээр Гаалийн ерөнхий газарт ирүүлсэн.<br>Зөрчлийн талаарх товч дурьдвал “Иргэн Н.Ө-ийн дайвар ачаа болох биологийн идэвхит бүтээгдэхүүнийг иргэн Т.Өлзийсүрэн, И.Басхүү нар 2023 оны 09 дүгээр сарын 17-ны өдөр Англи улсаас Чингис Хаан олон улсын нисэх буудлаар онгоцоор ирэхдээ авчирч Монгол Улсын хилээр хууль бусаар нэвтрүүлсэн” гэх зөрчил гаргасан.<br>2402000025 дугаартай зөрчлийн хэрэгт шалган шийдвэрлэх ажиллагааг хуульд заасны дагуу явуулан 2024 оны 03-р сарын 05-ны өдөр Зөрчлийн тухай хуулийн 6.6 дугаар зүйлийн 2 дахь хэсэгт заасны дагуу иргэн Түмэн-Өлзийгийн Өлзийсүрэн 0012511 дугаартай шийтгэлийн хуудасаар 100000 төгрөг, иргэн Идэшийн Басхүүг 0012801 дугаартай шийтгэлийн хуудасаар 100000 төгрөг торгож шийдвэрлэсэн. Тус зөрчилд | 2024.01.01-2024.06.05 | 90 |

| | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| | | | | | холбогдох биологийн идэвхит бүтээгдэхүүн нь бодит байдалд байхгүй байсан ба энэ зөрчлийг иргэн Н.Ө-ийн зөрчлийн хэрэгт Эм, эмнэлгийн хэрэгслийн хяналт зохицуулалтын газрын харьяаллын дагуу шийдвэрлэхээр болсон.<br>**Зөрчлийн 2402000048 дугаартай хэрэг:**<br>Сүхбаатар дүүрэг дэх Цагдаагийн газрын нэгдүгээр хэлтсээс 2024 оны 01-р сарын 20-ны өдрийн 30ии 1/526 тоот "Тус хэлтсийн 3-0543 дугаартай гомдол, мэдээлэлд зөрчил шалган шийдвэрлэх ажиллагаа явуулахад Гаалийн ерөнхий газрын улсын байцаагчийн харьяаллын дагуу шалгах зөрчил болох нь тогтоогдож байх тул Зөрчлийн тухай хуулийн тусгай ангийн 11.2 дүгээр зүйлийн 1.1 дэх хэсэгт заасныг удирдлага болгон харьяаллын дагуу эд зүйлсийн хамт шилжүүлэв. Нийт 14 ширхэг согтууруулах ундаа" гэсэн гомдол шилжүүлэх тухай албан бичгийг Гаалийн ерөнхий газарт ирүүлсэн.<br>Зөрчлийн талаарх товч дурьдвал "2024 оны 01-р сарын 16-ны өдөр 22 цаг 14 минутын үед Сүхбаатар дүүргийн 3 дугаар хорооны нутаг дэвсгэрт зөвшөөрөлгүйгээр гар дээрээс архи согтууруулах ундаа худалдан борлуулахаар цахим орчинд байршуулж, хүргэлтээр худалдан борлуулахаар хүргэлтээр ирсэн" гэх зөрчил гаргасан.<br>2402000048 дугаартай зөрчлийн хэрэгт шалган шийдвэрлэх ажиллагааг хуульд заасны дагуу явуулан 2024 оны 02-р сарын 20-ны өдөр Зөрчлийн тухай хуулийн 6.5 дугаар зүйлийн 15 дахь хэсэгт заасны дагуу иргэн Одхүүгийн Тэнгисийг 0012510 дугаартай шийтгэлийн хуудасаар 500000 төгрөгөөр торгож зөрчилд холбогдох 14 шил согтууруулах ундааны зүйлсийг хурааж шийдвэрлэсэн. | | |
| 3. | Хууль тогтоомж, эрх зүйн актын хэрэгжилт | Хэрэгжилт, гүйцэтгэлээр | - | Гаалийн бүрдүүлэлттэй холбоотой хууль тогтоомж, журам, зааврыг боловсронгуй болгоход санал санаачлагатай ажилласан байна. | Гаалийн бүрдүүлэлт, холбогдох хууль тогтоомж, журам зааврыг боловсронгуй болгон ажлын хүрээнд дараах саналыг гарган ажилласан байна. Үүнд:<br>1. "Гаалийн байгууллагаас хүүхдийн эрхийг хангах, хамгаалахад чиглэсэн үйл ажиллагааны 2024 оны төлөвлөгөө"-ний төсөлд<br>2. ГЕГ-ын даргын 2022 оны А/341 дүгээр тушаалын хавсралтаар батлагдсан "Гаалийн зуучлагчийн үйл ажиллагаанд хяналт тавих журам"-ыг шинэчлэн боловсруулах ажлын хүрээнд дараах саналыг гарган ажиллалаа. Үүнд: Журмын төслийн Гурав. Гаалийн зуучлагчийн үйл ажиллагааны зохицуулалт хэсгийн 3.8-д заагдсан Мэдүүлэгчийн нууцыг задруулахгүй, хууль бусаар ашиглахгүй байж холбогдох хуулийн хэрэгжилтийг хангаж ажиллана гэснийг Мэдүүлэгчийн нууцыг задруулахгүй, хууль бусаар ашиглахгүй, бусдад дамжуулахгүй байж холбогдох хуулийн хэрэгжилтийг хангаж ажиллана гэж өөрчлөх. | 2024.01.01-2024.06.05 | 90 |

| | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| 4. | Нэгжийн эрсдэлийн удирдлагыг хэрэгжүүлсэн байдал | Хэрэгжилт, гүйцэтгэлээр | - | 1. Бүрдүүлэлтийн цахим төвийн эрсдэлийн удирдлагыг оновчтой хэрэгжүүлж, эрсдэлийг таньж тогтоосон, ангилж санд бүртгэсэн байна. | Бичиг баримтын шалгалт хийх явцад гаалийн улсын байцаагч нарын гаргаж буй алдаа, дутагдалын байдлыг судлан ажиллаж байна.<br>ГЕГ-ын Зөрчилтэй тэмцэх газраас ирүүлсэн 2024 оны 03-р сарын 22-ны өдрийн 229, 5-р сарын 29-ний өдрийн 405 дугаартай дотоод зурваст дурдагдсан бичиг баримтын шалгалт хийх үед гарсан алдаа, дутагдлыг дахин гаруулахгүй байх үүндээс Бүрдүүлэлтийн цахим төвийн албан хаагч нарын мэдээлэл хуваалцах дотоод сүлжээ вэйбэр групп-т мэдээллийг байршуулж зөрчлөөс урьдчилан сэргийлэн ажиллаж байна. | 2024.01.01-2024.06.05 | 90 |
| 5. | Үүрэг даалгаврын биелэлт | Хэрэгжилт, гүйцэтгэлээр | - | Удирдлагаас өгсөн үүрэг даалгаврыг бүрэн хэрэгжүүлсэн байна. | 1. Мэдээллийн технологийн төвд ГЕГ-ын Бүрдүүлэлтийн цахим төвийн эрх бүхий албан тушаалтан нар бичиг баримтын шалгалт хийх явцдаа илрүүлсэн зөрчлийг КАЙС программ-д шивэх боломжтой болгох талаар 2024 оны 03-р сарын 21-ний өдрийн 37 дугаар дотоод зурвасыг хүргүүлэн МТГ-ын ГУАБ Н.Мөнхзултай КАЙС программын шийдлийг ярилцан “301022 Бүрдүүлэлтийн цахим төв” дэд хэсгийг нэмж өөрчлөлт оруулсан.<br>2. Гаалийн ерөнхий газраас Татвар орлогын төлөвлөгөөг биелүүлэх ажлын хэсэгт 10 дугаар бүлгийн 2023, 2024 оны 03-р сард хийсэн бүрдүүлэлтийн судалгааг удирдлагад танилцуулсан.<br>3. Төвийн даргаас үүрэг болгосоны дагуу “Албан тушаалын тодорхойлолт шинэчлэн боловсруулах ажлын хэсгийн хийх ажлын төлөвлөгөөний хавсралт”-ад заагдсаны дагуу “Бүрдүүлэлтийн цахим төвийн” 4 Албан тушаалын тодорхойлолтод саналаа өгсөн.<br>4. Албан бичгийн едок програмаар хуваарилагдан ирсэн 4 хүсэлт, албан бичгийг хуулийн хугацаанд нь шийдвэрлэн ажилласан. | 2024.01.01-2024.06.05 | 90 |
| 6. | Ажлын цаг ашиглалт | Хэрэгжилт, гүйцэтгэлээр | - | 1.Алба хаагчдын ажлын цагийг бүрэн бүртгэж, хяналт тавьсан байна.<br>2. Ажлын цаг ашиглалт 90 хувиас доошгүй байна. | • Бүрдүүлэлтийн цахим төвийн албан хаагч нарын ажлын цагийг бүртгэлд хяналт тавьж ажилласан.<br>• 2024 оны эхний хагас жилд ажлын нийт 112 хоног ажиллахаас 112 хоног ажилласан. Өвчтэй, чөлөөтэй, ажил тасласан өдөр байхгүй. Илүү 40 цаг ажилласан. | 2024.01.01-2024.06.05 | 100 |

## Нэмэлт үүрэг даалгавар (арга хэмжээ)-ын биелэлт

| Д/д | Үүрэг даалгавар (арга хэмжээ) | Шалгуур үзүүлэлт | Суурь түвшин | Хүрэх түвшин | Хүрсэн түвшин (биелэлт) | Эхэлсэн, дууссан хугацаа | Биелэлт ийн хувь |
|---|---|---|---|---|---|---|---|
| 1. | Нийт алба хаагчдыг үүрэгжүүлэх, мэдээ, тайлан гаргах, үүрэг даалгаврын биелэлтийг хангах, удирдлагыг мэдээллээр хангах, хариуцлага хяналтыг нэмэгдүүлэхээр ажлын хуваарийг хийж төвийн даргад танилцуулан, батлуулж, үйл ажиллагаанд мөрдөж ажиллах | Хэрэгжилт, гүйцэтгэлээр | - | Үүрэг даалгаврыг хугацаанд нь бүрэн биелүүлсэн байна. | Төвийн даргаас үүрэг болгосоны дагуу ГУАБ, ГУБ нарын давхар хариуцан ажиллах ажил үүргийн хуваарийн төслийг боловсруулан, ГУАБ нараас санал авч нэгтгэн, удирдлагад хянуулан батлуулан өдөр тутмын үйл ажиллагаандаа хэрэгжүүлэн ажиллаж байна. Үүнд:<br>• ГУАБ нарын хариуцсан ажлын хуваарийг улирлаар баталсан. /БТКУС, газар хороогоор хуваариласан/,<br>• ГУАБ, ГУБ нарын давхар хариуцсан ажил үүргийн хуваарийг мөн улирлаар төвийн дарга баталсан ба үйл ажиллагаандаа мөрдөн ажиллаж байна. /01-24, 93-97 бүлэг | 2024.01.01 - 2024.06.05 | 95 |

**Хоёр. Мэдлэг, ур чадвараа дээшлүүлэх зорилт, арга хэмжээний биелэлт**

| Д/д | Зорилтыг хэрэгжүүлэх арга хэмжээ | Шалгуур үзүүлэлт | Гүйцэтгэлийн түвшин | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| | | | Суурь түвшин | Хүрэх түвшин | Хүрсэн түвшин (биелэлт) | Эхэлсэн, дууссан хугацаа | Биелэлт ийн хувь |
| | 1 | 2 | 3 | 4 | 5 | 6 | 7 |
| 1. | Гаалийн ерөнхий газар болон ажлын байранд зохион байгуулагдсан сургалтад бүрэн хамрагдаж мэдлэг чадварыг нэмэгдүүлэх | Хэрэгжилт, гүйцэтгэлээр, сургалтын тоогоор | | Сургалтад бүрэн хамрагдсан байна. | Олон Улсын Валютын сангийн санхүүжилтээр 2024 оны 04-р сарын 08-ны өдрөөс 11-ний өдөр “Мөнгө угаах гэмт хэрэгтэй тэмцэх, мөрдөн шалгах ажиллагааны дэвшилтэд арга техник” сэдэвт 4 хоногийн сургалтад хамрагдаж сертификат гардан авсан. | 2024.01.01-2024.06.05 | 100 |
| 2. | Гаалийн бүрдүүлэлтийн үйл ажиллагаа болон бүрдүүлэлтийн бичиг баримтын зөрчлийг илрүүлэх чиглэлтэй холбоотой шинээр гарсан хууль, тогтоомж, тогтоол, журам, зааврыг тухай бүр уншиж судлан, хууль эрх зүйн мэдлэгээ сайжруулах | Хэрэгжилт, гүйцэтгэлээр, | | Хууль эрх зүйн мэдлэг сайжирч, өдөр тутмын үйл ажиллагаандаа хэрэгжүүлсэн байна. | Үйл ажиллагаатай холбоотойгоор шинээр гарсан холбогдох хууль, тогтоол, журам, заавартай танилцан үйл ажиллагаандаа мөрдөн ажиллаж байна. Үүнд:<br>- 2024.05.01-ний өдрийн ЗГ-ын 180 дугаар тогтоолоор “Гаалийн албан татвараас чөлөөлөх мал, амьтны тэжээл, тэжээлийн нэмэлт болон улаанбуудайн грилын жагсаалт” батлагдсан тул тухайн жагсаалтад хамрагдах 11 БТКУС-ын кодтой танилцан, уншиж судалсан. | 2024.01.01-2024.06.05 | 100 |

**ТАЙЛАН ГАРГАСАН:**

ГААЛИЙН УЛСЫН АХЛАХ БАЙЦААГЧ  
*( Албан тушаал )*

О. ШАГДАР / ........................................ /  
*( Нэр, гарын үсэг )*

2024.06.10  
*( Огноо )*

1044

*Засгийн газрын Хэрэг эрхлэх газрын даргын 2023 оны 98 дугаар тушаалын 8 дугаар хавсралт*

# БҮРДҮҮЛЭЛТИЙН ЦАХИМ ТӨВИЙН ГААЛИЙН УЛСЫН АХЛАХ БАЙЦААГЧ ОДОНЖИЛ ОВОГТОЙ ШАГДАРЫН 2024 ОНЫ ЭХНИЙ ХАГАС ЖИЛИЙН АЖЛЫН ГҮЙЦЭТГЭЛ, ҮР ДҮН, МЭРГЭШЛИЙН ТҮВШИНГ ҮНЭЛЭХ ҮНЭЛГЭЭНИЙ ХУУДАС (ГҮЙЦЭТГЭХ АЛБАН ТУШААЛТАН)

Байгууллагын нэр: Гаалийн ерөнхий газар

Нэгжийн нэр: Бүрдүүлэлтийн цахим төв

## 1. Гүйцэтгэлийн зорилт, арга хэмжээний биелэлт

| Д/д | Зорилтыг хэрэгжүүлэх арга хэмжээ | Арга хэмжээний гүйцэтгэлд өгсөн оноо | Төлөвлөсөн хугацаанд гүйцэтгэсэн байдал | Нийлбэр оноо | Үнэлгээний багийн хянан баталгаажуулж, дахин үнэлсэн оноо |
|---|---|---|---|---|---|
| | 1 | 2 | 3 | 4 | 5 |
| | Оноо | 60 хүртэл | 10 хүртэл | 70 хүртэл | |
| **Зорилт 1. Олон улсын хууль ёсны худалдааг хөнгөвчлөх, түүний аюулгүй байдлыг хамгаалахийг хэрэгжүүлсэн арга хэмжээний биелэлт** | | | | | |
| 1. | Хууль ёсны гадаад худалдааг хөнгөвчлөх чиглэлээр зохион байгуулсан арга хэмжээ | 53.2 | 9 | 62.7 | |
| 2. | Гаалийн бүртгэгдсэн мэргэжилтний үйл ажиллагаа | 53.2 | 9 | 62.7 | |
| 3. | Үндсэн шалгуурт тусгагдаагүй бусад чиг үүргийн хэрэгжилт | 53.2 | 9 | 62.7 | |
| 4. | Гаалийн байгууллагын 2024 оны Авлигын эсрэг үйл ажиллагааны төлөвлөгөөний хэрэгжилтийг хангах | 53.2 | 9 | 62.7 | |
| **Зорилт 2. Улсын хилээр хууль бусаар бараа, тээврийн хэрэгслийг нэвтрүүлэхтэй тэмцэхийг хэрэгжүүлсэн арга хэмжээний биелэлт** | | | | | |
| 1. | Гаалийн хилээр нэвтрүүлэх барааны бичиг баримтын шалгалт хийсэн байдал | 53.2 | 9 | 62.7 | |
| 2. | Гаалийн бүрдүүлэлтэд гарсан алдаа болон зөрчил илрүүлэлт, шийдвэрлэлт, алдааг бууруулах чиглэлээр зохион байгуулсан ажил | 53.2 | 9 | 62.7 | |
| 3. | Гаалийн бүрдүүлэлтийн горимын хэрэгжилт, гаалийн тариф, гарал үүслийн хяналт | 53.2 | 9 | 62.7 | |
| 4. | Барааны ангилал, гаалийн үнэ, үнэлгээг үнэн зөв мэдүүлэх, тодорхойлох чиглэлээр зохион байгуулсан ажил | 53.2 | 9 | 62.7 | |
| **Зорилт 4. Гаалийн байгууллагын дэд бүтэц, чадавхыг бэхжүүлэхийг хэрэгжүүлсэн арга хэмжээний биелэлт** | | | | | |
| 1. | Өргөдөл, гомдол, маргааныг шийдвэрлэсэн байдал | 53.2 | 9 | 62.7 | |
| 2. | Хууль тогтоомж, эрх зүйн актын хэрэгжилт | 53.2 | 9 | 62.7 | |
| 3. | Үүрэг даалгаврын биелэлт | 53.2 | 9 | 62.7 | |
| 4. | Ажлын цаг ашиглалт | 53.2 | 9 | 62.7 | |

| Нэмэлт үүрэг даалгаврын биелэлт | | | | | |
|---|---|---|---|---|---|
| 1. | Бүрдүүлэлтийн цахим төвийн ажлын байрны засварыг хариуцсан ажлын хэсэгт орж санаачлагатай ажиллах | 53.2 | 9 | 62.7 | |
| | Дундаж оноо: | 53.2 | 9 | 62.7 | |

## 2. Мэдлэг, ур чадвараа дээшлүүлэх зорилт, арга хэмжээний биелэлт

| Д/д | Зорилтыг хэрэгжүүлэх арга хэмжээ | Арга хэмжээний биелэлтийн хувь | Нийт (15 хүртэл оноогоор) | Үнэлгээний багийн хянан баталгаажуулж, дахин үнэлсэн оноо |
|---|---|---|---|---|
| | 1 | 2 | 3 | 4 |
| 1. | Гаалийн ерөнхий газар болон ажлын байранд зохион байгуулагдсан сургалтад бүрэн хамрагдаж мэдлэг чадварыг нэмэгдүүлэх | 86.7 | 13 | |
| 2. | Гаалийн бүрдүүлэлтийн үйл ажиллагаа болон бүрдүүлэлтийн бичиг баримтын зөрчлийг илрүүлэх чиглэлтэй холбоотой шинээр гарсан хууль, тогтоомж, тогтоол, журам, зааврыг тухай бүр уншиж судлан, хууль эрх зүйн мэдлэгээ сайжруулах | 86.7 | 13 | |
| | Дундаж оноо | 86.7 | 13 | |

## 3. Хандлага, ёс зүй, ур чадварын үнэлгээ (Нэгжийн даргын үнэлгээ)

| Д/д | Үзүүлэлт | Нэгжийн даргын үнэлгээ (0-7 оноо) | Үнэлгээний багийн хянан баталгаажуулж, дахин үнэлсэн оноо |
|---|---|---|---|
| | 1 | 2 | 3 |
| 1. | Хандлага, ёс зүй | 7 | |
| 2. | Дүн шинжилгээ хийх | 7 | |
| 3. | Асуудал шийдвэрлэх | 7 | |
| 4. | Хариуцлагатай байдал | 7 | |
| 5. | Ажлын цаг ашиглалт | 7 | |
| | Ур чадварын үзүүлэлт (ажлын онцлогоос хамаарсан) | | |
| 6. | Мэргэжлийн ур чадвар 1. | 7 | |
| 7. | Мэргэжлийн ур чадвар 2. | 7 | |
| 8. | Мэргэжлийн ур чадвар 3. | 7 | |
| | Дундаж оноо | 7 | |

## 4. Хандлага, ёс зүй, ур чадварын үнэлгээ (Хамт олны үнэлгээ)

| Д/д | Үзүүлэлт | Хамт олны үнэлгээ (0-8 оноо) |
|---|---|---|
| | 1 | 2 |
| 1. | Хандлага, ёс зүй | 8 |
| 2. | Багаар ажиллах | 8 |
| 3. | Харилцаа | 8 |
| | Дундаж оноо | |

## 5. Гүйцэтгэлийн үнэлгээ

| Д/д | Үнэлгээний үзүүлэлт | Үзүүлэлт тус бүрийн оноо |
|---|---|---|
| 1. | Гүйцэтгэлийн зорилт, арга хэмжээний биелэлт *(Нэмэлт үүрэг даалгавар (арга хэмжээ)-ын биелэлт орно.)* | *(70 хүртэлх оноо)* 62.2 |
| 2. | Мэдлэг, ур чадвараа дээшлүүлэх зорилт, арга хэмжээний биелэлт | *(15 хүртэлх оноо)* 13 |

| | | |
|---|---|---|
| 3. | Хандлага, ёс зүй, ур чадварын үнэлгээ<br>*( Нэгжийн даргын үнэлгээ )* | *(7 хүртэлх оноо)* 7 |
| 4. | Хандлага, ёс зүй, ур чадварын үнэлгээ<br>*(Хамт олны үнэлгээ)* | *(8 хүртэлх оноо)* 8 |
| 5. | Үнэлгээний оноонд орсон өөрчлөлт<br>*(Аргачлалын 6 дугаар хэсэгт заасан холбогдох заалтыг бичих)* | *(..... оноо)* |
| **Нийт оноо =**<br>(Гүйцэтгэлийн зорилт, арга хэмжээний оноо + Мэдлэг, ур чадвараа дээшлүүлэх зорилт, арга хэмжээний оноо + Хандлага, ёс зүй, ур чадварын оноо *(Нэгжийн даргын болон хамт олны үнэлгээ)* ) - Аргачлалын 6 дугаар хэсгийн холбогдох заалтын дагуу хассан оноо + Аргачлалын 6 дугаар хэсгийн холбогдох заалтын дагуу нэмсэн оноо | | 90.2 |

***Үнэлгээ өгсөн:*** ***Нэгжийн дарга***

Бүрдүүлэлтийн цахим төвийн дарга ........................ /Э.Лхагвасүрэн/
*(албан тушаал)* *(гарын үсэг)* *(албан хаагчийн нэр)*

2024. 06. 12 *(огноо)*

***Үнэлгээтэй танилцаж, зөвшөөрсөн:*** ***Төрийн жинхэнэ албан хаагч:***

Гаалийн улсын ахлах байцаагч ........................ /О.Шагдар/
*(албан тушаал)* *(гарын үсэг)* *(албан хаагчийн нэр)*

2024.06.13 *(огноо)*

***Үнэлгээг хянасан:***

*Үнэлгээний багийг төлөөлж ахлагч:*

ГЕГ-ын дэд даргын албан үүргийг түр орлон гүйцэтгэгч ........................ /Г.Энхтайван/
*(албан тушаал)* *(гарын үсэг)* *(албан хаагчийн нэр)*

2024.07.26 *(огноо)*

*Үнэлгээний багийн нарийн бичгийн дарга:*

ГЕГ-ын Хүний нөөцийн хэлтсийн даргын албан үүргийг түр орлон гүйцэтгэгч ........................ /Ж.Баясгалан/
*(албан тушаал)* *(гарын үсэг)* *(албан хаагчийн нэр)*

........................ *(огноо)*

***Үнэлгээг баталгаажуулсан:*** ***Төсвийн шууд захирагч***

ГЕГ-ын дарга ........................ /Р.Отгонжаргал/
*(албан тушаал)* *(гарын үсэг)* *(албан хаагчийн нэр)*

........................ *(огноо)*